

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2025.07.18

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

Иргэний нисэхийн ерөнхий газар /ИНЕГ/-ын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

ИНЕГ-ын 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайд, ТНБД-ын тушаалын биелэлт, Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 6 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **85,6%**-тай байна.

Яамнаас Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд туссан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө баталж, холбогдох харьяа байгууллагуудыг хэрэгжүүлэгч байгууллагаар тогтоогоогүй тул эдгээр бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг үнэлгээнд оруулаагүй болно.

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. ИНЕГ-ын 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээний хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт заалт	Үүнээс						Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
	100%	90%	70%	50%	30%	0%		
147	55	9	33	14	20	2	14	74,6%

2.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг дүгнэвэл:

Нийт заалт	Үүнээс				Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
5	3	2	-	-	60%

2.3. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт:

Нийт заалт	Үүнээс				Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
45	25	7	6	6	78,1%

2.4. ТНБД-ын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт:

Нийт заалт	Үүнээс				Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
1	1	-	-	-	100%

2.5. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:

Мэдээлэл		Нийт заалт	Үүнээс					Биелэлтийн хувь
			100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	
ИНЕГ	төсөв, гүйцэтгэл	6	2	2	-	-	2	85%
	хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт	5	3	1	-	-	1	92,5%
	бусад	8	5	-	-	-	3	100%
Нийт		19	10	3	-	-	6	93,0%

2.6. Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээ:

Мэдээлэл	Нийт заалт	Үүнээс					Биелэлтийн хувь
		100%	70%	30%	0%	хамаа ралгүй	
Нийт	46	36	2	1	1	6	94,2%

Төлөвлөлтийн байдал:

ИНЕГ нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахдаа ХШҮДАГ-аас өгсөн зөвлөмжийн дагуу арга хэмжээнүүдийг хариуцах хэлтэс, албадыг нэр заан тусгаж, хэрэгжүүлэх арга хэмжээний хүрэх түвшнийг улирлаар хуваан яамны төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөсөн боловч тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд яам болон ИНЕГ, ИНҮТ-ийн оролцох үүрэг, хариуцлагыг ялгаатай тодорхойлох зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Мөн Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам” шинэчлэн батлагдсантай холбоотой байгууллагуудын Гүйцэтгэлийн

төлөвлөгөөний суурь болон зорилтот түвшинг тоо, хувиар илэрхийлж болохуйцаар шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Хэрэгжилтийн байдал:

1) ИНЕГ-ын 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайд, ТНБД-ын тушаалын биелэлт, Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 6 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **85,6%**-тай байна. Яамнаас Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд туссан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө баталж, холбогдох харьяа байгууллагуудыг хэрэгжүүлэгч байгууллагаар тогтоогоогүй тул эдгээр бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг үнэлгээнд оруулаагүй болно.

2) Дээрх үзүүлэлтүүдээс Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хамгийн бага буюу 60%-аар үнэлэгдсэн нь АНУ руу шууд нислэг хийх бэлтгэл ажил удаашралтай байгаагаас шалтгаалсан байна.

3) 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 147 арга хэмжээний хэрэгжилт 85,6% байна. Үүнээс 48,1% нь эхний хагас жилд хүрэх түвшиндээ бүрэн хүрсэн болон хүрэх шатандаа, 51,9% нь төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй буюу хэрэгжилт хангалтгүй байна.

4) Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан хэрэгжилт хангалтгүй байгаа 36 арга хэмжээний 24 нь бодлого, стратеги, төлөвлөгөө, дүрэм, журам, аргачлал, стандарт боловсруулах, судалгаа хийх, зөвлөмж, заавар өгөх, үзлэг шалгалт хийх зэрэг хөрөнгө санхүүжилт шаардагдахгүй, удирдлага, зохион байгуулалтыг сайжруулан хийх боломжтой ажлууд байна.

5) Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилтуудаар нь авч үзвэл:

Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь
Зорилт 1: Олон улсын нислэг үйлдэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлнэ.	12	70%
Зорилт 2: Эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгоно.	11	68.2%
Зорилт 3: Олон улсын иргэний нисэхийн байгууллага (icao)-ын стандарт, шаардлагад нийцүүлэн монгол улсын агаарын навигацийн үйлчилгээний аюулгүй, үр ашигтай, хүртээмжтэй байдлыг бодлого, зохицуулалтаар хангана.	5	65.7%
Зорилт 4: Агаарын тээврийн салбарын хүрээлэн буй орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээ авах, нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтын хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх, бодлого, зохицуулалтаар хангана	5	82.5%
Зорилт 5: Олон улсын туршлага, чиг хандлагатай уялдуулан нисэх буудлын үйл ажиллагааны бодлогын санал боловсруулах, бодлогын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх	17	81.2%
Зорилт 6: Иргэний нисэхийн салбарын аюулгүй байдлын зохицуулалтыг хийнэ.	30	83.0%
Зорилт 7: Иргэний нисэхийн салбарт зохицуулалтыг үнэмлэхжүүлэлт, гэрчилгээжүүлэлтээр хийх.	11	97.1%

Зорилт 8: Иргэний нисэхийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт тавина.	5	94%
Зорилт 9: Осол зөрчил давтагдахаас урьдчилан сэргийлнэ.	1	50%
Зорилт 10: Иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын мэдээллийн ил тод байдлыг хангана.	2	80%
Зорилт 11: Олон улсын иргэний нисэхийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	8	55.7%
Зорилт 12: Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангана.	12	66.7%
Зорилт 13: Салбарын хууль тогтоомж, дүрэм журмыг шинэчлэхэд болон хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, удирдлагаар хангана.	15	60,7%
Зорилт 14: Үр ашиггүй зардлыг бууруулж, батлагдсан төсвөө хэмнэнэ.	6	86.7%
Зорилт 15: Бодлого, хөтөлбөр, төсөл, хууль тогтоомж, засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулахад дэмжлэг үзүүлнэ.	2	80%
Зорилт 16: ИНЕГ-ын үйл ажиллагаанд дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангана.	2	85%
Зорилт 17: иргэний нисэхийн аюулгүй байдлыг сайжруулна.	3	83.3%
Зорилт 18: иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангуулах, өгөгдлийн сангийн бүртгэл хөтлөх, хяналт тавих.	2	60%
Нийт		74,6%

6) 2025 онд 2.3 сая зорчигч, 12.0 мянган тн ачаа тээвэрлэхээр төлөвлөснөөс эхний хагас жилийн 1,063,245 зорчигч 4623.9 тонн ачаа тээвэрлэсэн үзүүлэлттэй, Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулиар батлагдсан хуваарийн дагуу улсын төсөвт 30.0 тэрбум төгрөгийг бүрэн төвлөрүүлсэн байна.

7) 2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж өгсөн зөвлөмжүүдээс дараах зөвлөмжүүдийн хангалтгүй хэвээр байна. Үүнд:

- ИНЕГ-ын албан хаагчдыг төрийн албан хаагч болгох, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулах зэрэг ажлуудыг 2025 оны I сард багтаан дуусгах,
- Монгол Улс, АНУ хооронд шууд нислэг үйлдэх бэлтгэл ажлыг эрчимжүүлж, 2025 онд багтаан нислэгийг эхлүүлэх;
- 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг яаралтай батлан I улиралд багтаан сонгон шалгаруулалтуудыг зохион байгуулах, ИНЕГ-ын хөрөнгө оруулалтаар болон урсгал зардлаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах;
- Иргэний нисэхийн ерөнхий газрын дунд хугацааны стратеги төлөвлөгөө, Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны журам, Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны үндэсний төлөвлөгөө, Албадлагын дүрэм, Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр зэрэг бичиг баримтуудыг батлах хөрөнгө, санхүүжилт шаардагдахгүй ажлуудыг яаралтай дуусгах;

Дөрөв. Санал, зөвлөмж

1. ИНЕГ-т ажиллаж буй албан хаагчдыг төрийн албаны ерөнхий шалгалтад хамруулах, албан тушаалын тодорхойлолтуудыг шинэчлэн Төрийн албаны

зөвлөлөөр хянуулан батлуулах, төрийн албаны ерөнхий шалгалтад тэнцсэн, шаардлага хангасан албан хаагчдыг яаралтай томилох, үлдсэн сул ажлын байранд “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-д заасны дагуу тусгай шалгалтыг зохион байгуулж, шаардлага хангасан иргэдийг томилох зэрэг ажлуудыг 2025 оны III улиралд багтаан дуусгах;

2. Агаарын харилцааны хэлэлцээр байгуулах, үзэглэх, хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах, нислэгийн тоо, чиглэлийг нэмэгдүүлэх болон Монгол Улс, АНУ хооронд шууд нислэг үйлдэх бэлтгэл ажлыг эрчимжүүлэх;
3. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн аудит шалгалтын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлан хэрэгжүүлж ажиллах, санхүүгийн сахилга батыг сайжруулах, алдаа, дутагдал гаргахгүй байхад анхаарч хяналтыг сайжруулах;
4. ИНЕГ-ын хөрөнгө оруулалтаар болон урсгал зардлаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах;
5. Иргэний нисэхийн дүрэм, журмууд, Иргэний нисэхийн аюулгүй байдлын журам, Иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтын журам, тэдгээрийг дагалдан гарах төлөвлөгөө, заавар, стандарт батлах, Иргэний нисэхийн ерөнхий газрын дунд хугацааны стратеги төлөвлөгөө, салбарын хүний нөөцийн стратеги, Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрүүдийг шинэчлэх зэрэг санхүүжилт шаардахгүй хэрэгжүүлэх боломжтой ажлуудыг яаралтай дуусгах зохион байгуулалтын арга хэмжээ авах;
6. Бүсийн нислэгийн хөдөлгөөний төвийн барилгын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулах, “Дэлүүн болдог” нисэх буудлын барилгын ажил, “Өлгий” нисэх буудлын өргөтгөлийн барилгын ажлыг хэрэгжүүлэх, “Буянт-Ухаа” олон улсын нисэх буудлыг түшиглэн хүмүүнлэгийн тусламжийн төв, сургалтын төв байгуулах, “Чингис хаан” олон улсын нисэх буудлыг өргөтгөх, “Шатахуун хангамжийн байгууламж”, “Airport hotel”, “Отгонтэнгэр”, Буйр нуур “4С” ангилал бүхий нисэх буудал байгуулах ажлыг эхлүүлэх, томоохон сум, суурин газар, аялал жуулчлалын бүсүүдэд ерөнхий зориулалтын агаарын хөлгийн байнгын болон түр ажиллагаатай хөөрч буух зурвас, нисдэг тэрэгний талбай байгуулах зэрэг бүтээн байгуулалтын ажлуудыг төлөвлөсөн хугацаанд багтаан дуусгах;
7. Бүтэц зохион байгуулалт өөрчлөгдсөн болон хяналт-шинжилгээний журамд өөрчлөлт орсонтой холбогдуулан Гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэчлэхдээ дараах зүйлсийн анхаарах. Үүнд:
 - Тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд ИНБЗГ болон ИНЕГ, ИНҮТ болон бусад харьяа байгууллага, компаниудын оролцох үүрэг, хариуцлагыг ялгаатай тодорхойлж, хэрэгжүүлэх хугацааг уялдуулах.
 - Суурь болон зорилтот түвшинг тоо, хувиар илэрхийлж болохуйцаар шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, улирал бүрээр хүрэх боломжтой, бодитойгоор төлөвлөх.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР